

ЕРДИЙН ДААТГАГЧИЙН ТӨЛБӨРИЙН ЧАДВАРЫГ ТООЦОХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмын зорилго нь ердийн даатгалын үйл ажиллагаа эрхэлдэг компани /цаашид “даатгагч” гэх/-ийн даатгуулагчийн өмнө гэрээгээр хүлээсэн үүргээ хугацаанд нь бүрэн биелүүлэхэд хүрэлцэхүйц хэмжээний хөрөнгөтэй эсэх, төлбөрийн чадвар нь зохих түвшинд хангагдсан эсэхийг тогтоож, хяналт тавихад оршино.

Хоёр. Нэр томьёо

2.1. Энэ журамд хэрэглэсэн нэр томьёог дор дурдсан утгаар ойлгоно:

2.1.1. “Нийт хөрөнгө” гэж даатгагчийн эзэмшиж байгаа эсвэл түүний хяналтад байгаа мөнгөөр хэмжигдэх эдийн засгийн нөөц баялагийг ;

2.1.2. “Зөвшөөрөгдөхгүй хөрөнгө” гэж даатгагчийн төлбөрийн чадварын үзүүлэлтэд сөргөөр нөлөөлж болохуйц хөрөнгүүдийг ;

2.1.3. “Зөвшөөрөгдөх хөрөнгө” гэж даатгагчийн зөвшөөрөгдөхгүй хөрөнгөнөөс бусад хөрөнгийг ;

2.1.4. “Зайлшгүй байх хөрөнгө” гэж даатгуулагчийн өмнө гэрээгээр хүлээсэн үүргээ хугацаанд нь зохих түвшинд биелүүлэхэд зайлшгүй байх шаардлагатай хөрөнгийн хэмжээг ;

2.1.5. “Төлбөрийн чадварын зохистой харьцаа” гэж даатгуулагчийн өмнө гэрээгээр хүлээсэн үүргээ хугацаанд нь бүрэн биелүүлэхэд зохих түвшинд хангагдсан хөрөнгөтэй эсэхийг харуулсан харьцааг ;

2.1.6. “Нийт өр төлбөр” гэж даатгагчийн өнгөрсөн үйл явдлын үр дүнд үүссэн бусад этгээдийн өмнө хүлээх өнөөгийн санхүүгийн үүрэг хариуцлагыг ;

2.1.7. “Орлогд тооцоогүй хураамжийн нөөц” гэж даатгалын гэрээний хугацаатай уялдуулан хувь тэнцүүлэх аргаар тооцоолж тайлант хугацаанд орлогоор хүлээн зөвшөөрөөгүй байгаа даатгалын хураамжийн хэсгийг ;

2.1.8. “Санхүүгийн байдлын тайлан” гэж Сангийн сайд, Санхүүгийн зохицуулах хорооны даргын хамтарсан тушаалаар батлагдсан даатгалын компанид мөрдөгдөх “Санхүүгийн тайлангийн маягт, тодруулга”-д тусгагдсан Санхүүгийн байдлын тайланг ;

2.1.9. “Банкны харилцах, хадгаламж” гэж Монгол банкнаас банкны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан, тусгай зөвшөөрөлтэй холбоотой аль нэг албадлагын арга хэмжээнд ороогүй, холбогдох этгээдэд үл хамаарах банкинд байгаа харилцах, хадгаламжийг ;

2.1.10. “Гадаадын банкин дахь харилцах, хадгаламж” гэж тухайн улсынхаа эрх бүхий байгууллагаас банкны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан, тусгай зөвшөөрөлтэй холбоотой аль нэг албадлагын арга хэмжээнд ороогүй, холбогдох этгээдэд үл хамаарах банкинд байгаа харилцах, хадгаламжийг ;

2.1.11. “Дотоодын банк бус санхүүгийн байгууллагад итгэлцлээр байршуулсан мөнгөн хөрөнгө” гэж Хорооноос банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан, тусгай зөвшөөрөлтэй холбоотой аль нэг албадлагын арга хэмжээнд

ороогүй, холбогдох этгээдэд үл хамаарах банк бус санхүүгийн байгууллагад байршуулсан мөнгөн хөрөнгийг ;

2.1.12. “Гадаадын банк бус санхүүгийн байгууллагад итгэлцлээр байршуулсан мөнгөн хөрөнгө” гэж тухайн улсынхаа эрх бүхий байгууллагаас банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан, тусгай зөвшөөрөлтэй холбоотой аль нэг албадлагын арга хэмжээнд ороогүй, холбогдох этгээдэд үл хамаарах банк бус санхүүгийн байгууллагад байршуулсан мөнгөн хөрөнгийг ;

2.1.13. “Төв банкны үнэт цаас” гэж Монголбанкны мөнгөний бодлогын нээлттэй захын хэрэгсэл бөгөөд хямдруулсан хэлбэрээр арилжигдаж, тогтоосон хугацааны дараа нэрлэсэн үнээр эргэн төлөгдөх үнэт цаасыг;

2.1.14. “Авлага” гэж даатгалын авлага, санхүүгийн түрээсийн авлага, бусад авлагыг;

2.1.15. “Үнэт цаас” гэж Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас, Аймаг нийслэлийн гаргасан өрийн хэрэгсэл, Компанийн өрийн хэрэгслийг;

2.1.16. “Санхүүгийн түрээс” гэж Санхүүгийн түрээсийн тухай хуулийн 3.1, 3.2-т заасныг;

2.1.17. “Үл хөдлөх хөрөнгө” гэж Иргэний хуулийн 84.3 дахь хэсэгт заасан, холбогдох хууль, журмын дагуу баталгаажсан эрхийн гэрчилгээтэй үл хөдлөх хөрөнгийг /Аливаа зээлийн барьцаанд тавьсан, эсхүл төлбөрийн баталгаа болгосон хөрөнгийг үл хөдлөх хөрөнгөд оруулж тооцохгүй/;

2.1.18. “Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас” гэж Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 4 дүгээр зүйлд заасныг;

2.1.19. “Хөрөнгө оруулалтын сан” гэж Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 6.2.1-д заасан нээлттэй эсхүл хаалттай санг;

2.1.20. “Компанийн өрийн хэрэгсэл” гэж Хорооноос тусгай зөвшөөрөл авсан даатгагчийн холбогдох этгээдээс бусад компанийн өрийн хэрэгслийг;

2.1.21. “Хөдлөх хөрөнгө” гэж даатгагчийн үндсэн үйл ажиллагаандаа ашиглаж байгаа биет үндсэн хөрөнгө буюу эд хогшил, техник тоног төхөөрөмж, тээврийн хэрэгслийг;

2.1.22. “Өмчлөх бусад хөрөнгө” гэж нөхөн төлбөрийн тооцоонд хүлээн авсан хөрөнгийг;

2.1.23. “Бусад хөрөнгө” гэж даатгагчийн санхүүгийн байдлын тайлангийн актив дахь нийт хөрөнгийн дүнгээс энэ журмын 4.4.1-4.4.24-д заасан хөрөнгийн дүнг хасч тооцсон дүнг.

Гурав. Төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлт

3.1. Даатгагчийн төлбөрийн чадварын байдлыг төлбөрийн чадварын зохистой харьцаагаар тодорхойлно.

3.2. Төлбөрийн чадварын зохистой харьцааг даатгагчийн зөвшөөрөгдөх хөрөнгийн дүнгээс өр төлбөрийн дүнг хасч ялгаврыг зайлшгүй байх хөрөнгийн дүнд хуваах замаар буюу дараах томъёогоор тооцно.

$$ТЧЗХ = \frac{ЗХ - \Theta Т}{ЗБХ} * 100\% , \text{ Үүнд:}$$

ТЧЗХ – төлбөрийн чадварын зохистой харьцаа

ЗХ – зөвшөөрөгдөх хөрөнгийн дүн

ӨТ – өр төлбөрийн дүн
ЗБХ – зайлшгүй байх хөрөнгийн дүн

3.3. Зөвшөөрөгдөх хөрөнгийн дүнг даатгагчийн нийт хөрөнгөөс зөвшөөрөгдөхгүй хөрөнгийн дүнг хасах замаар буюу дараах томъёогоор тооцно.

$$ЗХ = НХ - ЗqX$$
, Үүнд:

ЗХ – зөвшөөрөгдөх хөрөнгийн дүн
НХ – нийт хөрөнгийн дүн /Даатгагчийн санхүүгийн байдлын тайлангийн нийт хөрөнгийн дүн/
ЗqX – зөвшөөрөгдөхгүй хөрөнгийн дүн

3.4. Өр төлбөрийн дүнг даатгагчийн нийт өр төлбөрөөс орлогод тооцоогүй хураамжийн нөөцийн 10 хувийг хасах замаар буюу дараах томъёогоор тооцно.

$$ӨТ = НӨТ - ОТХН * 10\%$$
, Үүнд:

ӨТ – өр төлбөрийн дүн
НӨТ – нийт өр төлбөрийн дүн /Даатгагчийн санхүүгийн байдлын тайлангийн нийт өр төлбөрийн дүн/
ОТХН – орлогод тооцоогүй хураамжийн нөөцийн дүн

3.5. Даатгагчид зайлшгүй байх хөрөнгийн хэмжээг тооцоходоо дараах 3 үзүүлэлтийн хамгийн их дүнг үндэслэн тогтоох буюу дараах томъёогоор тооцно:

$$ЗБХ = \max (ОТХx; НХДx; ДСДХ)$$
, Үүнд:

ЗБХ – зайлшгүй байх хөрөнгийн дүн
ОТХx – энэ журмын 3.5.1-д заасан дүн
НХДx – энэ журмын 3.5.2-д заасан дүн
ДСДХ – энэ журмын 3.5.3-д заасан хэмжээ

3.5.1. Агаарын хөлгийн, автотээврийн хэрэгслийн, бүх төрлийн хариуцлагын даатгалын хэлбэрийн орлогод тооцсон хураамжийн 40 хувь дээр бусад даатгалын хэлбэрийн орлогод тооцсон хураамжийн 20 хувийг нэмсэн дүн. Тус дүнг дараах томъёогоор тооцно;

$$ОТХx = ОТХ^1 * 40\% + (НОТХ - ОТХ_1) * 20\%$$
, Үүнд:

ОТХ¹ – Агаарын хөлгийн, автотээврийн хэрэгслийн, бүх төрлийн хариуцлагын даатгалын хэлбэрийн орлогод тооцсон хураамжийн дүн
НОТХ – Нийт орлогод тооцсон хураамжийн дүн

3.5.2. Агаарын хөлгийн, автотээврийн хэрэгслийн, бүх төрлийн хариуцлагын даатгалын хэлбэрийн сүүлийн 3 жилд нэхэмжилсэн хохирлын дундаж дүнгийн 50 хувь дээр бусад хэлбэрийн сүүлийн 3 жилд нэхэмжилсэн хохирлын дундаж дүнгийн 20 хувийг нэмсэн дүн. Тус дүнг дараах томъёогоор тооцно;

$$\text{НХДх} = \frac{\text{НХ}_t^1 + \text{НХ}_{t-1}^1 + \text{НХ}_{t-2}^1}{3} * 50\% + \frac{((\text{ННХ}_t - \text{НХ}_t^1) + (\text{ННХ}_{t-1} - \text{НХ}_{t-1}^1) + (\text{ННХ}_{t-2} - \text{НХ}_{t-2}^1))}{3} * 20\%$$

Үүнд:

- НХ_t^1 - Агаарын хөлгийн, автотээврийн хэрэгслийн, бүх төрлийн хариуцлагын даатгалын хэлбэрийн тухайн жилийн тайлант хугацаанд нэхэмжилсэн хохирлын дүн
- НХ_{t-1}^1 - Агаарын хөлгийн, автотээврийн хэрэгслийн, бүх төрлийн хариуцлагын даатгалын хэлбэрийн өмнөх жилийн тайлант хугацаанд нэхэмжилсэн хохирлын дүн
- НХ_{t-2}^1 - Агаарын хөлгийн, автотээврийн хэрэгслийн, бүх төрлийн хариуцлагын даатгалын хэлбэрийн 2 жилийн өмнөх тайлант хугацаанд нэхэмжилсэн хохирлын дүн
- ННХ_t - Тухайн жилийн тайлант хугацаанд нийт нэхэмжилсэн хохирлын дүн
- ННХ_{t-1} - Өмнөх жилийн тайлант хугацаанд нийт нэхэмжилсэн хохирлын дүн
- ННХ_{t-2} - 2 жилийн өмнөх тайлант хугацаанд нийт нэхэмжилсэн хохирлын дүн

3.5.3. Хорооноос тогтоосон дүрмийн сангийн доод хэмжээ

3.6. Нэхэмжилсэн хохирлын дүнг тухайн жилийн тайлант хугацаанд олгосон нийт нөхөн төлбөрийн дүн дээр нэхэмжилсэн боловч олгоогүй хохирлын дүнг нэмж, өссөн дүнгээр тооцож гаргана.

3.7. Зөвшөөрөгдөхгүй хөрөнгийн дүнг хөрөнгийн ангилал бүрээр байршуулах дээд хэмжээнээс хэтрүүлэн байршуулсан хөрөнгийн дүн, нэгжид ногдох дээд хэмжээнээс хэтрүүлэн байршуулсан хөрөнгийн дүн болон байршуулсан хөрөнгийн эрсдэлтэйд тооцсон хэсэг буюу зөвшөөрөгдөх хөрөнгийг бууруулах дүнгүүдийн нийлбэрээр дараах томъёогоор тооцож гаргана:

$$\text{ЗqX} = \text{НХЗq} + \text{ХЗq}_н + \text{ЗХБ} \quad , \text{ Үүнд:}$$

- ЗqХД – зөвшөөрөгдөхгүй хөрөнгийн дүн
- НХЗq – нийт хөрөнгийн зөвшөөрөгдөхгүй дүн
- ХЗq_н – нэгжид ногдох тухайн хөрөнгийн зөвшөөрөгдөхгүй дүн
- ЗХБ – зөвшөөрөгдөх хөрөнгийг бууруулах дүн

3.8. Нийт хөрөнгийн зөвшөөрөгдөхгүй дүн нь энэ журмын 4.4-д заасан хөрөнгийн ангилал бүрээр тооцсон зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс хэтрүүлэн байршуулсан хөрөнгийн нийлбэр байх бөгөөд тухайн хөрөнгөд байршуулах дээд хувийг нийт хөрөнгийн дүнгээр үржиж, гарсан дүнг баланс дахь тухайн хөрөнгийн дүнгээс хасч, хөрөнгийн ангилал тус бүрээр гарсан эерэг утгатай ялгавруудыг нэмэх /сөрөг утгатай гарсан бол тэгтэй тэнцүү гэж тооцох/ замаар буюу дараах томъёогоор тооцож гаргана:

$$\text{HXЗq} = \sum_{i=1}^n [(X_i - \text{HX} * \max_i) \geq 0] , \text{Yүнд:}$$

HXЗq – нийт хөрөнгийн зөвшөөрөгдөхгүй дүн
 X_i – баланс дахь тухайн хөрөнгийн дүн
 HX – нийт хөрөнгө
 max_i – тухайн хөрөнгийг байршуулах дээд хувь
 n – энэ журмын 4.4-д заасан хөрөнгийн ангиллын тоо
 i – энэ журмын 4.4-д заасан хөрөнгийн ангиллын дугаар

3.8.1. Хөрөнгийн “Даатгалын үндсэн үйл ажиллагаанд зориулан авсан зээл” ангиллаарх зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс хэтрүүлэн байршуулсан хөрөнгийн дүнг даатгагчийн дүрмийн сангийн хөрөнгийг хөрөнгө байршуулах дээд хувиар үржүүлэн, гарсан дүнг баланс дахь тухайн хөрөнгийн дүнгээс хасах замаар тооцож гаргана.

3.9. Нэгжид ногдох тухайн хөрөнгийн зөвшөөрөгдөхгүй дүн нь энэ журмын 4.4-д заасан хөрөнгийн ангилал бүрээр тооцсон нэгжид ногдох зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс хэтрүүлэн байршуулсан хөрөнгийн нийлбэр байх бөгөөд тухайн хөрөнгөд байршуулах нэгжид ногдох дээд хувийг нийт хөрөнгийн дүнгээр үржиж, гарсан дүнг тухайн нэгжид байршуулсан хөрөнгийн дүнгээс хасч, хөрөнгийн ангилал тус бүрээр гарсан эерэг утгатай ялгавруудыг нэмэх /сөрөг утгатай гарсан бол тэгтэй тэнцүү гэж тооцох/ замаар буюу дараах томъёогоор тооцож гаргана:

$$\text{XЗq}_H = \sum_{i=1}^n [(X_i^H - \text{HX} * \max_i^H) \geq 0] , \text{Yүнд:}$$

XЗq_H – нэгжид ногдох тухайн хөрөнгийн зөвшөөрөгдөхгүй дүн
 X_i^H – тухайн нэгжид ногдох хөрөнгийн дүн
 HX – нийт хөрөнгийн дүн
 max_i^H – нэгжид ногдох хөрөнгийн дээд хувь
 n – энэ журмын 4.4-д заасан хөрөнгийн ангиллын тоо
 i – энэ журмын 4.4-д заасан хөрөнгийн ангиллын дугаар

3.9.1. Хөрөнгийн “Даатгалын үндсэн үйл ажиллагаанд зориулан авсан зээл” ангиллаарх нэгжид ногдох зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс хэтрүүлэн байршуулсан хөрөнгийн дүнг даатгагчийн дүрмийн сангийн хөрөнгийг нэгжид ногдох хөрөнгө байршуулах дээд хувиар үржүүлэн, гарсан дүнг тухайн хөрөнгийн нэгжид ногдох дүнгээс хасах замаар тооцож гаргана.

3.10. Зөвшөөрөгдөх хөрөнгийг бууруулах дүнг энэ журмын 4.4.1-4.4.5, 4.4.7-4.4.10, 4.4.14-4.4.18, 4.4.20-4.4.25-д заасан хөрөнгийн зөвшөөрөгдөх хэмжээнд байгаа дүнг энэ журмын 4.4-д заасан зөвшөөрөгдөхгүй хөрөнгийн харгалзах хувиар үржүүлж, авлага, үнэт цаас, өмчлөх бусад хөрөнгийн 4.2.3-т заасан ангиллаарх хөрөнгийн дүнг энэ журмын 4.4-д заасан тухайн ангилалд харгалзах зөвшөөрөгдөхгүй хөрөнгийн хувиар үржүүлэн, эдгээр үржвэрүүдийг нэмэх замаар буюу дараах томъёогоор тооцно:

$$\text{ЗХБ} = \sum_{i=1}^n (AX_i * \text{ЗqXX}_i) , \text{Yүнд:}$$

ЗХБ – зөвшөөрөгдөх хөрөнгийг бууруулах дүн
 AX_i – энэ журмын 4.4.1-4.4.5, 4.4.7-4.4.10, 4.4.14-4.4.18, 4.4.20-4.4.25-д заасан хөрөнгийн зөвшөөрөгдөх хэмжээнд байгаа ангиллаарх

хөрөнгийн дүн, авлага, үнэт цаас, өмчлөх бусад хөрөнгийн хувьд энэ журмын 4.2.3-т заасан ангиллаарх хөрөнгийн дүн
 $3qXX_i$ – энэ журмын 4.4-д заасан зөвшөөрөгдөхгүй хөрөнгийн хувь
 n – хөрөнгийн ангиллын тоо
 i – хөрөнгийн ангиллын дугаар

3.11. Даатгагчийн төлбөрийн чадварын зохистой харьцаа нь 100 хувь буюу түүнээс илүү байвал зохино.

3.12. Хэрэв даатгагчийн төлбөрийн чадварын зохистой харьцаа 100 хувиас доош байвал даатгагчийг төлбөрийн чадваргүй болсонд тооцно.

Дөрөв. Хөрөнгийн ангилал

4.1. Даатгагчийн хөрөнгөөс авлага, үнэт цаас, өмчлөх бусад хөрөнгө хэлбэрээр үүссэн хөрөнгийг эрсдлээр нь ангилж даатгагчийн төлбөрийн чадварыг үнэлэхэд ашиглана.

4.2. Даатгалын компани нь үнэт цаас (Засгийн газрын үнэт цааснаас бусад), өмчлөх бусад хөрөнгө, авлагыг дор дурдсан байдлаар тухай бүр ангилна:

- 4.2.1. Хэвийн
- 4.2.2. Хугацаа хэтэрсэн
- 4.2.3. Чанаргүй, үүнээс:
 - 4.2.3.1. Хэвийн бус
 - 4.2.3.2. Эргэлзээтэй
 - 4.2.3.3. Муу

4.3. Энэ журмын 4.2-д заасан активын ангилалыг хугацааны үзүүлэлтээр нь дор дурдсан байдлаар дүгнэнэ:

4.3.1. Авлагыг хугацааны үзүүлэлтээр дүгнэх хүснэгт

Ангилал	Хэвийн	Хугацаа хэтэрсэн	Хэвийн бус	Эргэлзээтэй	Муу
Хугацааны үзүүлэлт	30 хүртэл хоногийн дотор байгаа	31-60 хоногийн дотор төлөгдөөгүй	61-90 хоногийн дотор төлөгдөөгүй	91-120 хоногийн дотор төлөгдөөгүй	121-ээс дээш хоногоор төлөгдөөгүй буюу гэмт хэргийн улмаас бий болсон авлага

4.3.2. Хувьцаа ба түүнтэй адилтган тооцох үнэт цааснаас бусад үнэт цаасыг хугацааны үзүүлэлтээр дүгнэх хүснэгт

Ангилал	Хэвийн	Хугацаа хэтэрсэн	Хэвийн бус	Эргэлзээтэй	Муу
Хугацааны үзүүлэлт	Үнэт цаас, үнэт цаасны хүүгийн эргэн төлөлт, хуваарьт заасан хугацаандаа төлөгдөж байгаа.	Үнэт цаас, үнэт цаасны хүүгийн эргэн төлөлт хийгдэлгүй хуваарьт заасан хугацаанаас 30 хүртэл хоног хэтэрсэн.	Үнэт цаас, үнэт цаасны хүүгийн эргэн төлөлт хийгдэлгүй хуваарьт заасан хугацаанаас 31-60 хоног хэтэрсэн.	Үнэт цаас, үнэт цаасны хүүгийн эргэн төлөлт хийгдэлгүй хуваарьт заасан хугацаанаас 61-90 хоног хэтэрсэн.	Үнэт цаас, үнэт цаасны хүүгийн эргэн төлөлт хийгдэлгүй хуваарьт заасан хугацаанаас 91-ээс дээш хоног хэтэрсэн.

4.3.3. Өмчлөх бусад хөрөнгийг хугацааны үзүүлэлтээр дүгнэх хүснэгт

Ангилал	Хэвийн	Хугацаа хэтэрсэн	Хэвийн бус	Эргэлзээтэй	Муу
Хугацааны үзүүлэлт	Өмчлөлд авснаас хойш 30 хүртэл хоногийн дотор борлогдоогүй	Өмчлөлд авснаас хойш 31-60 хүртэл хоногийн дотор борлогдоогүй	Өмчлөлд авснаас хойш 61-90 хүртэл хоногийн дотор борлогдоогүй	Өмчлөлд авснаас хойш 91-120 хүртэл хоногийн дотор борлогдоогүй	Өмчлөлд авснаас хойш 121 хоногоос дээш хугацаанд борлогдоогүй

4.4. Даатгагч нь дараах ангилал болон Хорооноос тогтоосон дээд хувь, нэгжид ногдох хөрөнгийн дээд хувийн дагуу нийт хөрөнгийн /даатгалын үндсэн үйл ажиллагаанд зориулан авсан зээлээс бусад хөрөнгийн хувьд/ дүнгээс тооцож, хөрөнгийг байршуулна:

д/д	Хөрөнгийн ангилал	Хөрөнгө байршуулах дээд хувь	Нэгжид ногдох хөрөнгийн дээд хувь	Зөвшөөрөгдөх үй хөрөнгийн хувь
	Баганын дүн	1	2	3
4.4.1.	Банкны харилцах, хадгаламж	100%	35%	0%
4.4.2.	Гадаадын банкин дахь харилцах, хадгаламж	2%	1%	50%
4.4.3.	Дотоодын банк бус санхүүгийн байгууллагад итгэлцлээр байршуулсан мөнгөн хөрөнгө	20%	5%	5%
4.4.4.	Гадаадын банк бус санхүүгийн байгууллагад байршуулсан мөнгөн хөрөнгө	2%	1%	100%
4.4.5.	Бэлэн мөнгө	2%	2%	0%
4.4.6.	180 хоногоос доош хугацаатай авлага /Даатгалын гэрээний дагуу хураамжийг хэсэгчлэн төлж байгаа тохиолдолд тухайн даатгалын хураамжийн авлага нь 180 хоногоос доош хугацаатай авлагад тооцогдоно/	20%	20%	Хэвийн бус авлага 50% Эргэлзээтэй авлага 75% Муу авлага 100%
4.4.7.	Банкны хадгаламжийн сертификат	50%	20%	0%
4.4.8.	Гадаадын банкин дахь хадгаламжийн сертификат	25%	10%	50%
4.4.9.	Засгийн газраас гаргасан өрийн хэрэгсэл	100%	100%	0%
4.4.10.	Төв банкны үнэт цаас	60%	60%	0%
4.4.11.	Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас	40%	20%	Хэвийн бус үнэт цаас 50% Эргэлзээтэй үнэт цаас 50% Муу үнэт цаас 100%
4.4.12.	Аймаг нийслэлийн гаргасан өрийн хэрэгсэл	60%	20%	
4.4.13.	Компанийн өрийн хэрэгсэл	20%	10%	
4.4.14.	Монголын хөрөнгийн биржийн хувьцаат компанийн хувьцаа – 1 ангилал	10%	5%	20%
4.4.15.	Монголын хөрөнгийн биржийн хувьцаат компанийн хувьцаа – 2 ангилал	5%	2%	30%
4.4.16.	Хөрөнгө оруулалтын нээлттэй сан	20%	10%	5%
4.4.17.	Хөрөнгө оруулалтын хаалттай сан	20%	10%	10%

4.4.18.	Дериватив санхүүгийн хэрэглүүр	10%	5%	100%
4.4.19.	Өмчлөх бусад хөрөнгө	5%	2,5%	Хэвийн бус ӨБХ 50%
				Эргэлзээтэй ӨБХ 75%
				Муу ӨБХ 100%
4.4.20.	Санхүүгийн түрээс	10%	5%	10%
4.4.21.	Үл хөдлөх хөрөнгө	25%	20%	10%
4.4.22.	Хөдлөх хөрөнгө	10%	5%	90%
4.4.23.	Даатгалын үндсэн үйл ажиллагаанд зориулан авсан биет бус хөрөнгө	5%	5%	80%
4.4.24.	Даатгалын үндсэн үйл ажиллагаанд зориулан авсан зээл	30%*	30%*	100%
4.4.25.	Бусад хөрөнгө	0%		100%
	Нийт хөрөнгийн дүн			

*Хувь нийлүүлсэн хөрөнгө буюу дүрмийн сангийн хөрөнгөөс тооцно.

Тав. Холбогдох этгээд болон түүнтэй холбоотой этгээдэд хөрөнгө оруулалт хийх хязгаарлалт

5.1. Даатгалын тухай хуулийн 27 дугаар зүйлд заасан хязгаарлалтаас гадна дараах этгээдэд хөрөнгө оруулалт хийхийг хязгаарлах бөгөөд энэхүү этгээд нь хөрөнгө оруулалт хийхэд эрсдэл бүхий этгээдэд тооцогдоно:

5.1.1. Даатгалын тухай хуулийн 61 дүгээр зүйлд заасан холбогдох этгээд;

5.1.2. Даатгагчийн болон холбогдох этгээдийн хувь нийлүүлэгч болон хувьцаа эзэмшигч;

5.1.3. Даатгалын компанийн хувь нийлүүлэгч, Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүн, гүйцэтгэх захирал, даатгалын салбарын захирал, тэдгээрийн өвөг эцэг, эмэг эх, эцэг, эх, эхнэр, нөхөр, ах, эгч, дүү, хүүхэд болон тэдэнд хяналтын багцаа эзэмшүүлдэг хуулийн этгээд, уг хуулийн этгээдийн хяналтын багцыг эзэмшдэг аливаа иргэн, хуулийн этгээд;

5.1.4. Барьцаа хөрөнгийн зах зээлийн үнэлгээ нь зээлийн үндсэн өр болон хүүгийн төлбөрийг барагдуулахад хүрэлцэхгүй байгаа иргэн, хуулийн этгээд;

5.1.5. Холбогдох этгээдтэй хэрэг, маргаан үүссэний улмаас эрх бүхий байгууллагаар хянагдаж, шалгагдаж байгаа этгээд;

5.1.6. Тухайн даатгалын компанийн даатгуулагч;

5.1.7. Даатгалын компани өөрөө холбогдох этгээд гэж үзсэн бусад этгээд.

Зургаа. Хяналт тавих

6.1. Энэ журмын нэгдүгээр хавсралт “СЗХ040хх” маягт болон хоёрдугаар хавсралт “СЗХ040хх” маягтын дагуу төлбөрийн чадвараа тооцож гарган улирал бүр санхүүгийн тайлангын хамт Хороонд ирүүлнэ.

6.2. Энэ журамд заасны дагуу даатгагч төлбөрийн чадваргүй болж болзошгүй болсон, эсхүл төлбөрийн чадваргүй болсон бол энэ талаар Хороонд нэн даруй бичгээр мэдэгдэнэ.

6.3. Хороо энэ журмын хэрэгжилтэд байнга хяналт тавих бөгөөд зөрчсөн этгээдэд Даатгалын тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

--ooOoo--

“Ердийн даатгагчийн төлбөрийн чадварыг тооцох журам”-ын нэгдүгээр хавсралт

Маягт СЗХ040хх

“.....” ХХК-ийн 20... оны дүгээр улирлын
Зөвшөөрөгдөхгүй хөрөнгийн дүн

№	Хөрөнгийн ангилал	Тайланг хугацааны эцсийн дүн	Хөрөнгө байршуулах дээд хувь	Нийт хөрөнгийн зөвшөөрөгдөхгүй дүн	Нэгжид ногдох хөрөнгийн дүн	Нэгжид ногдох хөрөнгийн дээд хувь	Нэгжид ногдох тухайн хөрөнгийн зөвшөөрөгдөхгүй дүн	Зөвшөөрөгдөх хэмжээнд байгаа хөрөнгийн дүн	Зөвшөөрөгдөхгүй хөрөнгийн хувь	Зөвшөөрөгдөх хөрөнгийг бууруулах дүн	Нийт зөвшөөрөгдөхгүй дүн
	Баганын дүн	1	2	3 = (1)*(2)	4	5	6 = (4)*(5)	7	8	9 = (7)*(8)	10 = 3+6+9
	Банкны харилцах, хадгаламж		100%			35%			0%		
	Гадаадын банкин дахь харилцах, хадгаламж		2%			1%			50%		
	Дотоодын банк бус санхүүгийн байгууллагад итгэлцлээр байршуулсан мөнгөн хөрөнгө		20%			5%			5%		
	Гадаадын банк бус санхүүгийн байгууллагад байршуулсан мөнгөн хөрөнгө		2%			1%			100%		
	Бэлэн мөнгө		2%			2%			0%		

180 хоногоос доош хугацаатай авлага <i>/Даатгалын гэрээний дагуу хураамжийг хэсэгчлэн төлж байгаа тохиолдолд тухайн даатгалын хураамжийн авлага нь 180 хоногоос доош хугацаатай авлагад тооцогдоно/</i>		20%			20%			Хэвийн бус авлага 50%		
								Эргэлзэт эй авлага 75%		
								Муу авлага 100%		
Банкны хадгаламжийн сертификат		50%			20%			0%		
Гадаадын банкин дахь хадгаламжийн сертификат		25%			10%			50%		
Засгийн газраас гаргасан өрийн хэрэгсэл		100%			100%			0%		
Төв банкны үнэт цаас		60%			60%			0%		
Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас		40%			20%			Хэвийн бус ҮЦ 50% Эргэлз ээтэй ҮЦ 50% Муу ҮЦ 100%		
Аймаг нийслэлийн гаргасан өрийн хэрэгсэл		60%			20%					
Компанийн өрийн хэрэгсэл		20%			10%					
Монголын хөрөнгийн биржийн хувьцаат компанийн хувьцаа – 1 ангилал		10%			5%			20%		
Монголын хөрөнгийн биржийн хувьцаат компанийн хувьцаа – 2 ангилал		5%			5%			30%		

“.....” ХХК-ийн 20... оны дүгээр улирлын төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлт

1. Зайлиггүй байх хөрөнгө / $1 = \max(1.1, 1.2, 1.3)$ /				
Үзүүлэлт		Дүн	Тооцох хувь	Тооцсон дүн
	1	2	3	4
1.1 Даатгалын хураамжид үндэслэх /Тухай тайлант хугацааны нийт орлогод тооцсонхураамж / (1.1.1 (4)+1.1.2 (4))				
	1.1.1 Агаарын хөлөг, авто тээврийн хэрэгсэл, бүх төрлийн хариуцлагын даатгалын хэлбэрийн орлогод тооцсон хураамж		40%	
	1.1.2 Бусад хэлбэрийн орлогод тооцсон хураамжийн 20%		20%	
1.2 Даатгалын нэхэмжлэлд үндэслэх /Сүүлийн 3 жилийн дунджид үндэслэн/ (1.2.1 (4)+1.2.2 (4))				
	1.2.1 Агаарын хөлөг, авто тээврийн хэрэгсэл, бүх төрлийн хариуцлагын даатгалын хэлбэрийн нөхөн төлбөр * 50%		50%	
	1.2.2 Бусад хэлбэрийн нөхөн төлбөр * 20%		20%	
1.3 Хорооноос тогтоосон дүрмийн сангийн доод хэмжээ				
2. Нийт хөрөнгө				
3. Зөвшөөрөгдөхгүй хөрөнгө				
4. Зөвшөөрөгдөх хөрөнгө / $4 = (2) - (3)$ /				
5. Өр төлбөр / $5 = \text{Нийт өр төлбөр} - \text{ОТХ} * 10\%$ /				
6. Төлбөрийн чадварын зохистой харьцаа $6 = (4-5) / 1 \geq 100\%$				